



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 59,200,000.00 (тавин есөн сая хоёр зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 6,577,777.76 (зургаан сая таван зуун далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан эд хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002205

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн
 386 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хьюндай старекс О, 95-44 УНИ, (арал-кмjwa37гагi801194)	2017	59,200,000.00	ш	1	59,200,000.00	6,577,777.76	52,622,222.24
	Нийт дүн					59,200,000.00 (тавин есөн сая хоёр зуун мянган)	6,577,777.76 (зургаан сая таван зуун далан долоон мянга долоон зуун далан долоон төгрөг далан зургаан мянгө)	52,622,222.24 (тавин хоёр сая зургаан зуун хорин хоёр мянга хоёр зуун хорин хоёр төгрөг хорин дөрвөн мянгө)